



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/87

Улаанбаатар хот

Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн
замналд улирлаас хамаарсан зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын “Дүрэм”-ийн 2.5.3, 3.1.19 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороонд байрлах Шадивлангийн уулзвараас Шадивлан эцэс хүртэл 2 км авто замд өвлийн улиралд хальтиргаа гулгаа үүсч эцсийн зогсоол руу нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал хангагдахгүй байх нөхцөл байдал үүсдэг тул Ч:22 “Шадивлан-Бөмбөгөр-Чингис СООСЭ-Далангийн зам” чиглэлийн замналд улиралаас хамаарсан зохицуулалт хийж жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэл мөрдөх чиглэлийн замналыг нэгдүгээр, зуны хуваарь буюу жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл мөрдөх чиглэлийн замналыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх өөрчлөлтийг 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс мөрдөх чиглэлийн зураглал, үйлчилгээний цагийн хуваарийг боловсруулж нэгдсэн даалгаварт тусгахыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс /Д.Галбадрах/-т, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилан таниулах ажлыг зохион байгуулахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/-т, тухайн чиглэлийн үйлчилгээг зохион байгуулж, зохицуулалт хийх, хэвийн ажиллагааг хангуулж ажиллахыг Зорчигч тэврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/-т, үйлчилгээг батлагдсан замналын дагуу явуулах, ажиллах цагийн хуваарийн мөрдөлтөд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /Ц.Мягмар/-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Булгаа/-д үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/65 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА





Д.ОТГОНБААТАР

Ч:22 "ШАДИВЛАН – БӨМБӨГӨР – ЧИНГИС СООСЭ ДС – ДАЛАНГИЙН ЗАМ"

Нийслэлийн тээврийн газрын 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/27 дугаар тушаалын ... дүгээр хавсралт




Нийслэлийн Тээврийн Газар
Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс



Тайлбар :


Эргэлтийн урт:	43 км	Шадивлан /баруун/	Эцсийн зогсоол	Газрын налуугийн градус /уруу/
Эргэлтийн хугацаа:	167 мин	Та Чи	Хоёр чиглэлдээ зогсдог зогсоол	Газрын налуугийн градус /өгсүүр/
Зогсох буудлын тоо:	73	Чингис Соосэ ДС	Нэг чиглэлдээ зогсдог зогсоол	Гэрлэн дохио
Дайран өнгөрөх уулзварын тоо:	18	Хөдөлгөөний чиглэл	Гудамжны нэр	Гүүр
		Энхтайвны өргөн чөлөө		Аюулгүйн тойрог

Нийслэлийн тээврийн газрын 2017 оны 10 дугаар сарын
...-ний өдрийн А/Б/Г дугаар тушаалын А/Б/Г дугаар хавсралт



Ч:22 “ШАДИВЛАН – БӨМБӨГӨР – ЧИНГИС СООСЭ ДС – ДАЛАНГИЙН ЗАМ”

Нийслэлийн Тээврийн Газар
Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс



Тайлбар :

Эргэлтийн урт:	47,2 км	Эцсийн зогсоол	Газрын налуугийн градус /уруу/
Эргэлтийн хугацаа:	167 мин	Хоёр чиглэлдээ зогсдог зогсоол	Газрын налуугийн градус /өгсүүр/
Зогсох буудлын тоо:	78	Нэг чиглэлдээ зогсдог зогсоол	Гэрлэн дохио
Дайран өнгөрөх уулзварын тоо:	18	Гудамжны нэр	Гүүр
			Аюулгүйн тойрог